



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 8/22

Улаанбаатар хот

┌ “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/08 дугаар захирамж, Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Багахангай дүүргийн 2026 оны төсөв батлах тухай” А/23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн суралцагчдын өсөлт хөгжлийг дэмжих, кальци, Д аминдэмийг нөхөх, ясны сийрэгжилтээс урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих, сүү сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Сүү” хөтөлбөрийг дүүрэгт үргэлжлүүлэн хэрэгжүүлсүгэй.

2.Арга хэмжээг нийслэл, дүүргээс олгосон санхүүжилтэд багтаан чанар үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Боловсролын хэлтэс (Ш.Баасансүрэн), Ерөнхий боловсролын 91, 94 дүгээр сургуулийн захирал (С.Болормаа, Э.Болормаа) нарт үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрт зарцуулагдах 32,887,100 (Гучин хоёр сая найман зуун наян долоон мянга нэг зуу) төгрөгийг сар бүрийн гүйцэтгэлд үндэслэн Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД